

2

ШИЛЖИЛТИЙН ЭДИЙН ЗАСАГ БОЛ ШИНЖЛЭХ УХААНЫ ШИНЭ САЛБАР МӨН

П. Лувсандорж

Удиртгал

Эдийн засгийн шинжлэх ухаан бол гуйланчлалыг үгүй хийх, баялгийг бүтээх арга ухааныг судалдаг олон жилийн түүхтэй хүн төрөлхтөний бүтээл. Эдийн засагчид хаандаа, төрдөө зөвлөж, нийгэмдээ, хүндээ тус болж ирсэн түүхтэй. К.Марксын номлолыг капитализмыг шүүмжлэгч, Дж.Кейнсын сургаалыг капитализмыг аврагч, А.Маршаллын төлөвлөгөөг социализмыг задлагч гэж ярих нь буй.

Монгол улс социализмаас татгалзах, хүн төрөлхтөний хөгжлийн нийтлэг замд орох жамтайг эдийн засгийн шинжлэх ухаан аль хэдийнээ нотлосон байх юм. "Социалистууд өөрсдийн авч үзэж байгаа асуудлуудыг шийдвэрлэхэд учрах бэрхшээлүүдийг дутуу үнэлж, хувийн өмчийг устгах замаар гачигдал, дутагдлаас хүн төрөлхтөнийг аварч болох тухай хэт яаруу дүгнэлт хийж байна"¹ гэж А.Маршалл 100 гаруй жилийн өмнө, социализмыг мэндлээгүй байхад нотолж байсан тухайн Дж.М.Кейнс гэрчилсэн байдаг.

Яарвал даарна гэж монголчууд өөрсдөө ярьдаг атлаа бусдыг дагаж буруу замаар будаа тээж, буцаад нийтлэг замтайгаа нийлэх гэж будилж яваа нь энэ. Эдийн засгийн шинжлэх ухааныг үнэлж, судалж, дагаж явахаас өөр замгүй гэсэн хатуугаас хатуу түүхэн сургамж үлдлээ. Эндээс бидний хийх хамгийн эхний дүгнэлт гэвэл, ардчилал, шинэчлэлийн аливаа асуудлыг шийдвэрлэхэд тохиолдож болох эерэг сөрөг талыг урьдчилан харах чадварыг дан гагц судалгаа, шинжилгээний үндсэн дээр олж чадна. Гэтэл судалгаагүй бодлого, бодлогогүй шийдвэр гарч байгаа нь төрийн түшмэдүүдийн өдөр тутмын үйл ажиллагааг судалгаа шинжилгээний суурь бүтээлээс дээгүүр тавьсны уршиг. Адам Смит үндэсний засаглалаас үндэсний баялгийг салгаж судлаад, орчин үеийн эдийн засгийн шинжлэх ухааныг үндэслэгч болсон түүхтэй байхад үндэсний засаглалыг үндэсний баялагтай холих буюу түүнээс дээгүүр

¹ А.Маршалл. Эдийн засгийн шинжлэх ухааны зарчмууд. I боть, 16 дахь тал.

тавьсан ямар ч оролдлого эдийн засгийн шинжлэх ухааныг ухраагч буюу устгагч болж түүхэнд орох аюултай.

Нийгмийн шинэчлэл нь социалист байсан орнуудаар зогсохгүй бусад улс орныг хамарч үечлэн явагдах дэлхий нийтийн түүхэн үйл явц билээ. Тэр нь шинжлэх ухааныг, түүний дотор эдийн засгийн шинжлэх ухааныг хэрэглэхгүйгээр бүтэх зүйл биш, энэ утгаар, нийгмийн шинэчлэл нь бүхэлдээ шинжлэх ухаан гэмээр.

Товчоор хэлбэл, нийгмийн шинэчлэл шинжлэх ухааны үндсэн дээр явагдаж, эргээд шинжлэх ухааныг, өөрийг нь, баяжуулах зүй тогтолтой. Шилжилтийн үед шинжлэх ухааны шинэ онол, шинэ зарчим, шинэ загвар, шинэ бодлого, шинэ зураглал бүтээх шинэ өргөн боломж эрдэмтэдэд, түүний дотор эдийн засагчдад олдож байгаа нь азтай хэрэг. Залуу эрдэмтэд, эдийн засагчид энэхүү ховор олдох боломжийг алдаж яав ч болохгүй, үүний тулд дан гагц эдийн засагчид энэхүү ховор олдох боломжийг алдаж яав ч болохгүй, үүний тулд дан гагц оюун ухааны шургуу хөдөлмөр хэрэгтэй. Ялангуяа социалист байсан орнуудад нийгмийн шинэчлэл хөгжлийн жамаар биш, шилжилтийн замаар хийгдэж байгаа нь шинжлэх ухааны хувьд онцгой анхаарал татаж байгаа юм. Энэ бол цөөхөн хэдэн орны, түүний дотор Монгол Улсын өвөрмөц зам.

Шилжилтийн эдийн засаг гэсэн эдийн засгийн шинжлэх ухааны бүхэл бүтэн шинэ салбар бий болж байна. Энд хүчээ үзэх хэрэгтэй, судлах зүйл хангалттай. Жишээ татъя: шилжилтийн эхний жилүүдийн засгийн газрууд эдийн засаг уналттай байхад номонд байдаггүй өсөлтийн бодлого явуулаад бүтээгүй. Манай засгийн газрууд мөнгөний талаар ч, санхүүгийн талаар ч хатуу бодлого явуулж байгаа гэнэ. Эдийн засгийн тэнцвэрийн онолоор бол дээрх хоёр бодлогын аль нэг нь хатуу байхад нөгөө нь заавал зөөлөн байж илүү үр дүнд хүрэх ёстой. Зөвхөн энэ хэдэн асуудлыг сайн судлахад шинэ онол гарч ч магад.

Өөрийн зууны туршид мэдлэгийн талаар тэргүүлж байсан А.Маршалл, Д.Рикардогийн олон бүтээлийг математик хэл дээр буулгаж тусалсан байх юм. Эдийн засгийн шинжлэх ухааныг хагас зууны туршид судалсан тэрээр "Түүнийг судалж эхлэх үед байснаасаа одоо би бага мэдлэгтэй байгаагаа өөрөө ухамсарлаж байна" гэж хэлсэн байх юм. Эдийн засгийн шинжлэх ухааныг хэдий хэр гүнзгий судалбал төдий хэр мэдлэг дутагддаг ажээ. Тэгэхлээр "их" мэдлэгтэнгүүд болж хоорондоо хоосон цэцэрхээд байвал шинжлэх ухааныг хөдөлгөж чадахгүй, харин ч устгаж магад.

Эдийн засгийн шинжлэх ухааныг судалсан, хэрэглэсэн хэр хэмжээгээр аж ахуйн амьдралыг ардчилах, зах зээлд шилжих үйл явцыг түргэсгэж чадна. Энэ утгаар, төрийн өмчийг хувьчлахаас хоцрохгүйгээр эдийн засгийн сургалт, судалгааг түргэн, хүчтэй өрнүүлмээр.

Урьдын үзэж судалсан эдийн засгийн ухаан одоогийн шаардлагыг хангахгүй. Хуучнаар зааж хүүхдийн толгойг эргүүлдэг багш, хувийн сэтгэлгээгээр шинжлэх ухааныг гутаадаг судлаачид цөөнгүй бий. сургалтын хөтөлбөр, судалгааны төслөөр шалгарагсадаар эдийн засгийн шинжлэх ухааны үндэсний чадавхийг шинэчлэн сэлбэх бодлого баймаар. Үүний хамт шинэ агуулгатай эдийн засгийн сургалт, судалгааг дорвитой өрнүүлэх үндэсний хөтөлбөр хэрэгжүүлмээр.

Хүүхэд, хөгшдөөс эхлээд хүн бүрийн амнаас "зах зээл" гэдэг үг гарах болсон цаг. Үүнийг хүн бүр зах зээлийн эдийн засгийг мэдээд байна гэвэл тэнэг хэрэг. Харин энэ бол зах зээлийн эдийн засгийн сургалт судалгааны хүрээнд нийгмийн эрэлт асар их байгааг олон түмэн нотлож буй хэрэг. Гэтэл одоогийн байдлаар, эдийн засгийн сургалтын хүрээнд нийлүүлэлт дутуу, судалгааныханд нь эрэлт дутуу, хоёуланд нь эрэлт, нийлүүлэлт зөрчилтэй байна.

Ингэлээ гээд, суралцагсадын тоог хязгаарлах, судалгаа хийгчдыг цомхотгох замаар уул зөрчлийг шийдвэрлэхэд хүрвэл зах зээлийн эсрэг ажиллагаа болно. Харин сургуулиудын хүрэлцээг нэмэгдүүлэхүйц, судалгааны эрэлтийг өсгөхүйц хүч чадалтай Засгийн газар, пүүсүүд яах аргагүй үгүйлэгдэж байна.

Эдийн засгийн сургалт, судалгаа зах зээлийн сонголттой холбогдон манай оронд зарчмын хувьд шинэ агуулгатай болж байна. Энэ бол нийгмийн бүх шинжлэх ухаанд хамаарагдана. Байгаль техникийн шинжлэх ухааны арга зүйн шинэчлэл манайд бас явагдах ёстой.

Эдийн засагч багш, судлаачид бид бол эдийн засгийн мэдлэгийн үндэсний шинэ сургууль төлөвшүүлэх гавъяатай бөгөөд төвөгтэй үйлсэд зүтгэж яваа улс. Энэ нь ялангуяа эдийн засгийн сургалт судалгаа явуулдаг их дээд сургуулиудад бүрэн хамаарагдана.

МУИС-ийн Эдийн Засгийн Сургууль сургалт, судалгаа хослон явуулдаг шинэ мэдлэгийн төв болон шинэчлэгдэж байгаа нь сайшаалтай. Эдийн засгийн сургуулийн бараг бүх салбар улсын захиалгатай судалгааны төсөл хэрэгжүүлэх болсон, төслийг хэрэгжүүлэхэд багш нар өргөн хамрагдах болсон. Энэ бол тэмдэглүүштэй зүйл.

1998 онд эдийн засгийн хөгжил, бодлого, удирдлагын судалгааны 8 төслийг хэрэгжүүлж дууссан. 1999 онд үндэсний тооцооны систем, маркетинг, менежмент, үндэсний бүртгэл, санхүү банкны шинэ тогтолцоо бүрдүүлэх судалгааны 3 төсөл хэрэгжүүлж дуусгасан. 2001 онд төрийн эдийн засгийн бодлогын онолын үндэс, өсөлтийн онолыг хөгжилд хэрэглэх үндэс, бүртгэл тайлагнал, аудитын тогтолцоо төлөвшүүлэх 3 төслийг хэрэгжүүлж дуусаад байна. Түүнээс гадна эдийн засгийн сургуулийн багш, судлаачид эдийн засгийн хөгжлийн үндэсний номлол, эдийн засгийн аюулгүй байдал, бөөний худалдааны сүлжээ, Монгол улсад эдийн засгийн шинжлэх ухааны үндэсний шинэ сургууль төлөвшүүлэх судалгааны төсөл, онолын сэдвүүд дээр ажиллаж байна.

Ер нь шинэ цаг үед багш бүхэн судалгаа хийдэг, судлаач бүхэн сургалт явуулдаг болж таарна. Ингэсэн цагт боловсрол чанартай, судалгаа бүтээлч болно. Багш, судлаач бидний үйл ажиллагааны стратегийн зорилт үүнд оршино.

Шинжлэх ухаан бол улс, үндэстний хил хязгаараас хальсан хүн төрөлхтөний нийтлэг бүтээл. Энэ зүйл эдийн засгийн шинжлэх ухаанд бүрэн хамаарагдана гэж хэлмээр байна. Энэ утгаар, бид эдийн засгийн шинжлэх ухааны сонгодог сургаал, онолуудыг судалдаг, суралцдаг, биширдэг, дагадаг. Тэдгээрийг баяжуулахад шилжилтийн онол хэрэгтэй. Сонгодог онолуудыг шилжилтийн практикт хэрэглэх ёстой. Энэ бол стратегийн ач холбогдолтой алдаж болохгүй ерөнхий чиг шугам. Гэхдээ хөгжилтэй зах зээлийн бүх онол шилжилтийн практикт шууд буух хөрстэй гэж хэлэх үндэс алга. Тийм нөхцөлд завсарын буюу шилжилтийн онол, шатласан буюу үе шаттай арга хэмжээ зайлшгүй.

1. Шилжилтийн арга, хэлбэр

Монгол Улсад Азийн гэхээсээ Европын загвартай илүү төстэй шилжилт явагдаж байгаа нь олон улсын эрдэмтэдийн судалгаагаар тогтоогдсон юм. Үүнийг тэд нийгэм-эдийн засгийн тогтолцооны хувьд ижилхэн, тэгээд бас ЭЗХТЗ-ийн хүрээнд хамтарсан үйл ажиллагаа явуулж байсантай холбон тайлбарлаж байгаа юм. Тэгээд ч Монгол Улс Азийн орон атлаа "Вашингтоны Консенсус" гэж нэрлэгддэг Европын арга замаар макро эдийн засгийн шинэтгэлийг микро түвшнийхээс түрүүлж "дээрээс нь доош" явуулсан онцлогтой, эндээс бас багагүй хохирол хүлээсэн сургамжтай.

Азийн шилжилтийн арга зам нь микро эдийн засгийн шинэтгэлээс эхэлж, зохион байгуулалтын шинэтгэл хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн газруудын шинэтгэл, тэдгээрийн хууль, эрхийн хүрээний шинэтгэл, үнийн шинэтгэлийг хамарсан билээ. Эдгээр шинэтгэлийг макро эдийн засгийн шинэтгэлээс, тухайлбал: төсвийн, мөнгөний, гадаад худалдааны шинэтгэлээс өмнө "доороос нь дээш" хэрэгжүүлсэн арга гэж болно. Энэ дараалал нь харьцангуй үр ашигтай барааны зах зээлийг дэмжих, нийлүүлэлтийг урамшуулахад үр нөлөөтэй гэж судлаачид үздэг. Хувийн секторын хөгжлийг дэмжихийн зэрэгцээ улсын үйлдвэрүүдийг шинэ нөхцөлд шилжүүлэх талаар хийсэн алхамууд үр дүнтэй болсон гэдэг. Түүнээс гадна ялгавартай үнэ, мөнгө, санхүүгийн талаар хийж байсан зохицуулалт нь үнийг хяналтаас гаргаж, хүчтэй инфляцийн дарамтанд орсон европ аргаас давуутай гэдэг. Азийн аргыг Монголын шинэчлэлд хэрэглэж болохыг үгүйсгэх үндэс байхгүй.

Эдийн засгийн шинэчлэлийн европ аргын хүрээнд зовлонгийн түргэн, жаргалын удаан гэдэгчилэн өөрчлөлтийг боломжтой тохиолдолд түргэн хийх бодлого явуулсан. Энэхүү шок эмчилгээний ашигтай үр дагаврыг нийгмийн бага зардал гэж үздэг. Гэвч түүнийг тооцоход нэн бэрх ажээ. Шок эмчилгээнийхэн болон градуалистуудын хоорондын мэтгэлцээн үргэлжилсэн хэвээр боловч ихэнх Европын орон эхний стратегийг дагасан байна. Тэдний туршлагаас банкны шинэчлэл, өмч хувьчлал гэх мэт дунд болон урт хугацаанд бүтцийн өөрчлөлт хийгдэх салбарт шок эмчилгээг хэрэглэх боломжгүй нь харагдсан, зарим алдаа дутагдал ч бас ажиглагдсан ажээ.

Эдийн засагч эрдэмтэд: Р.Портес, Нолан, Петер нар шилжилтийн үйл явцад дараах алдаанууд гарсан гэж үздэг. Үүнд:

- Микро эдийн засгийнхаас макро эдийн засгийн бодлогод илүү анхаарсан.
- Мөнгөний хэтэрхий хатуу бодлого явуулсан.
- Хэтэрсэн делавьлаци хийж, тохирохгүй ханшны бодлого явуулсан.
- Улсын үйлдвэрийн газруудыг өргөн хүрээгээр бодлогогүй хувьчилсан.
- ЭЗХТЗ-ийг яарч тараасан нь бүс хоорондын худалдааны уналтанд нөлөөлсөн.
- Хуучин тогтолцоог түргэн хугацаанд өөрчлөхөд гарч болох тулгамдсан асуудлуудыг дутуу тооцсон.
- Эдийн засгийн амьдрал, баталгааг хангахад Засгийн газрын үүрэг, ролийг дутуу үнэлсэн.
- Шилжилтийн явцад "зах зээл" гажуудах тохиолдолд төрөөс хэрэгжүүлэх ёстой арга хэмжээнүүдийн зэрэглэлийг урьдчилан харж чадаагүй.
- Улс төрийн тогтвортой орчинг бүрдүүлэхэд тохиолдох хүндрэлийг дутуу тооцоолсон гэдэг.

Эдгээр алдаа Монгол Улсын эдийн засгийн шилжилтийн үйл явцад ямар нэгэн хэмжээгээр гарсан гэх үндэс бий. Эдгээр алдааг дахин давтахгүйн тулд үндэсний судалгааг хөгжүүлэх хэрэгтэй. Төрийн бодлогын алдаа нь их төлөв хөгжсөн зах зээлтэй орнуудын туршлагыг шууд хуулбарласнаас, сурах бичиг барьж бодлого явуулснаас гарна. Ийм шүүмжлэл олон улсын хэмжээнд ч өрнөж байгаа нь нууц биш. Дэлхийн банкны эдийн засагч байсан Жозеф Стиглиц: Дэлхийн эдийн засгийн шилдэг "докторууд" гэж үнэлэгдэж ирсэн ОУВС, Дэлхийн Банк хоёр шилжилтийн орнуудад бэлэн жор тулгадаг, Барууны зөвлөхүүд өмч хувьчлалаар эд хөрөнгийг хамгаалах сэтгэл зүй төлөвшүүлнэ гээд сууж байхад шинэ эзэмшигчид нь эд хөрөнгөө хурдхан худалдаад хилийн чанадад активгаа байршуулж авилгал өрнүүлж байна гэсэн яггүй шуугиан дэгдээж байна гэж CNN нэгэн мэдээндээ өгүүлсэн билээ. Энэ хүн одоо тэр ажлаасаа гарсан, бүтээл нь Нобелийн шагналд дэвшсэн, дэлхийн шилдэг эдийн засагч.

Ийм алдаа бас үндэсний эдийн засгийн онцлогийг судалж амжаагүй, үндэсний зөвлөхүүдээсээ үг сонч сураагүйтэй холбоотой. Монгол Улс бол буурай хөгжилтэй, бага орлоготой хөгжиж

буй орон. Үндэсний судалгаа маш чухал.

Эдийн засгийн онолын дэлхийн сургуулиудын гол ялгаа нь эдийн засаг дахь төрийн оролцооны тухай асуудал байсаар ирсэн, одоо ч энэ мэтгэлцээн үргэлжилсээр, түүнд оролцох онол-арга зүйн бүрэн үндэслэлтэй. Шилжилтийн эдийн засгийн шинжлэх ухаан ч ийм мэтгэлцээний үр дүн, үргэлжлэл нь байх болно.

Шилжилтийн эдийн засгийг шинжлэх ухааны хувьд эдийн засгийн онолын шинжлэх ухаан, шилжилтийн орнуудын амьдралын практик хоёрын дундаас гарах эрлийз гэж төсөөлж болно. Энд сравнительная экономика, компаратив экономиксийн судалгааны арга хэрэглэх нь зүйтэй.

Шилжилтийн эдийн засгийн шинжлэх ухааны дэлхийн сургуулиуд үүсч эхлээд байна. Энд Будапештэд төвтэй Төв Европын их сургууль, Дэлхийн Банкны судалгааны баг, Вильям Дэвидсоны хүрээлэнгүүдийг нэрлэж болно. Түүний зэрэгцээ социалист байсан орнууд, түүний дотор Монгол Улс өөрсдийн сургуулийг төлөвшүүлэх ёстой. Хятад, Вьетнамын эдийн засагчдыг градуализмын зохиогчид гэж болно. Монголын эдийн засагчид шок эмчилгээний сургуулийн хамтран зохиогч байхын зэрэгцээ өөрийн бие даасан сургуулийг төлөвшүүлэх учиртай.

Монголын лидерүүд шилжилтийг цэглэнэ гэнэ, бас шилжилт гэх нь хуучинсаг үзэл гэнэ. Орнодийн эрдэмтэд шок трапей, градуализм хоёрыг эс тооцвол шилжилтийн онол гэж юу байхав гэнэ. Тэд сүр дуулиантай "Зах зээлийн социализм" гэгч онол сэргээд ирнэ гэж айдаг бололтой. Шилжилтээс тасраад олон зуун жил болсон хөгжилтэй орнуудын эрдэмтэдийг шилжилтийн зовлонг эдэлж амсч яваа ядуу орны судлаачид бид буруутгах учиргүй.

Харин, шилжилтийн эдийн засгийн ухааныг үүсгэх, хөгжүүлэх гавъяатай үйлст өөрсдийн гэсэн хувь нэмрийг оруулах хувь тавилантай улс гэсэн ойлголт дутагдаад байгааг бид өөрсдөө хүлээн зөвшөөрмөөр. Яагаад гэвэл, судлах зүйл нь социалист байсан цөөхөн орон, түүний дотор Монгол Улс. Эдгээр оронд шилжилт эхлээд дуусаагүй байна. Орон зай, цаг хугацаа, судлах зүйлсээр тодроод байгаа өөрийн гэсэн өнгөтэй эрдмийн энэ дэвжээнд хүчээ үзэх ёстой нь бид байх ёстой шүү.

2. Судлах зүйл

Шилжилтийн эдийн засгийн шинжлэх ухааны хүрээнд бид юуг судлах вэ гэвэл: зах зээлийн хуулиуд монголын эдийн засагт одоохондоо яагаад тохирохгүй байна, үндэсний эдийн засгийг яаж номонд нь оруулах вэ? гэсэн практик асуудал.

Бидний судалгаанаас үзэхэд шилжилтийн эхэн үедээ байгаа монголын эдийн засгийг "номоороо биш" гэмээр. Яагаад гэвэл зах зээлийн сонгодог онол одоогоор түүнд таарахгүй байна.

Эдийн засагт инфляц нүүрлээд байхад мөнгөний хангамжийг нэмээд байх уу? Эрэлтийн инфляц бол яахав, яг номоороо мөнгө их байвал үнэ өндөр байна, мөнгө бага байвал инфляц багасна гэнэ. Энэ бол монетаризмын сонгодог онол, түүний нийтлэг жор гэвэл инфляцийг багасгахын тулд мөнгийг багасгах хэрэгтэй. Гэтэл манайд мөнгөний ханш 5900 хувиар унасан, барааны хангамж 50 хувиар хомсдсон, инфляц дийлэгдэхээ байлаа гэж сэтгэл түгшээж байсан үед мөнгө дутагдаад байсан. Гайхмаар байгаа биз. Нэгэнт хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнийг нэмэгдүүлэх, газар тариалангийн ажлыг санхүүжүүлэх гээд л үнэхээр бодит хэрэгцээ байсан болохоор гүйлгээн дэх мөнгийг нэмээд байсан. Энэ бол тийм аюултай биш, манайд мөнгөний хэмжээг эрэлтийн адил сүрхий мэдэрдэггүй зардлын инфляц давамгайлж байсан.

Эрэлтийн инфляцийг мөнгийг хасах замаар дардаг бол зардлын инфляцийг дарахад үйлдвэрлэлийг дэмжих, барааны хангамжийг сайжруулах арга илүүтэй нийцнэ. Үйлдвэрлэл нь буураад байхад үнийг нь нэмээд байх уу? Үнэ буурахаар үйлдвэрлэл багасдаг. Үйлдвэрлэл нь буураад байхад үнийг нь нэмээд байх уу? Үнэ буурахаар үйлдвэрлэл багасдаг. Үйлдвэрлэл нь буураад байхад үнийг нь нэмээд байх уу? Үнэ буурахаар үйлдвэрлэл багасдаг. Үйлдвэрлэл нь буураад байхад үнийг нь нэмээд байх уу? Үнэ буурахаар үйлдвэрлэл багасдаг.

Эдийн засаг "номоороо биш" байхад "номоороо биш" бодлого явуулах болж байна уу?

Төр засгийн дээд байгууллагууд эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийг тодорхойлохдоо: 1992 онд үндэсний орлогын үйлдвэрлэлийг 8 хувиар өснө гэсэн нь бүтээгүй билээ. Эндээс аяндаа "номоороо биш" эдийн засагт "номоороо биш" бодлого явуулж болохгүй гэсэн шууд хариулт гарч байна. Эдийн засаг "номоороо биш" байхад номын дагуу бодлого явуулах нь зөв үү? Мөнгөний хатуу бодлого явуулж байна. Ийм бодлого дотооддоо мөнгөний хүүг нэмэгдүүлэх, гадаадын капиталыг татах, улмаар төлбөрийн тэнцлийн алдагдлыг багасгах, арилгах, ач холбогдолтой. Гэтэл шинээр төрж буй хувийн хэвшлийн аж ахуйнуудыг дэмжих зорилгод мөнгөний өндөр хүү нийцэхгүй байна. Эндээс "номоороо биш" эдийн засагт ном ёсны бодлогыг шууд хуулбарлан хэрэглэж болохгүй, түүнийг шилжилтийн эдийн засагт тохируулан саармагжуулах нь чухал гэсэн хариулт гарч байна. Ер нь "номоороо биш" эдийн засаг байгааг мэдэж номонд нь оруулах нь арга олох хэрэгтэй. Манайд эдэлхүүний аж ахуйгаас таваарын аж ахуйд жам ёсоор шилждэг шиг биш, төвлөрсөн төлөвлөгөөт аж ахуйгаас зориуд ухамсартайгаар зах зээлд шилжүүлэх өвөрмөц үйл явц явагдаж байна. Хамаг асуудлын учир үүнд байгааг хууль батлагч, бодлого явуулагч, шийдвэр гаргагч бүх албад ямагт анхаарч байвал зохилтой. Баталсан хууль, явуулсан бодлого, гаргасан шийдвэрийн хэрэгжилт тааруухан байгаагийн шалтгаан энд байж ч магад.

Жинхэнэ зах зээл нь нийгэмд хэрэгцээтэй барааны үйлдвэрлэлд зориулан нөөц баялгийг үр ашигтай хуваарилах; хэрэглээгээ дагасан үйлдвэрлэл явуулах; хамгийн өндөр ашиг олох; өрсөлдөхийн тулд өндөр чанартай шинэ бүтээгдэхүүн гаргах, хамгийн шинэ технологи хэрэглэх; байнга өөрчлөгдөж байдаг нөхцөлд маш түргэн дасах, ямагт уян хатан байх; хэрэглэгч, үйлдвэрлэгчдийн үйл ажиллагаа болон сонголт нь чөлөөтэй байх шинж төлөвийг эдийн засагт суулган ургуулдаг нь нийтлэг. Гэвч эдгээр шинж төлөв зах зээлийн хөгжлийн хэр хэмжээнээс шалтгаалан орон бүрд өвөрмөц, тухайлбал манайд зөвхөн үр хөврөлийн байдалтай.

Зах зээлийн гол субъект, объектууд, тэдгээрийн хооронд байх ёстой хэлхээ холбоо бүхэлдээ биш гэхэд үндсэндээ төлөвшиж, үндэсний эдийн засаг бүхэлдээ үгүй юмаа гэхэд түүний гол, гол салбар нь зах зээлийн эдийн засгийн дээрх шинж төлөвийг олж, тэнд зах зээлийн хуулиуд жинхэнэ ёсоор, "ёстой сурах бичигт байдаг шиг" үйлчилж эхэлсэн тухайд шилжилтийн үе төгслөө гэж болмоор. Тэгэхдээ шилжилтийг ямагт хөгжилтэй хобож ойлгох нь зөв.

3. Үндсэн асуудлууд

3.1. Сурах бичигт зах зээлийн нөхцөлд төрийн оролцоо эдийн засгийн өсөлтийг дэмжих биш, сааруулах нөлөөтэй гэж байдгийг бид мэднэ. Энэ бол хөгжилтэй зах зээлд хамаарагдахаас биш, бүх зах зээлд, тэр тусмаа шилжилтийн үеийн зах зээлд хамаарагдана гэсэн үг огт бишээ. Сурах бичгийн мөрөөр төрийн бодлого явуулж олон тэрбум өмч хөрөнгөө алдаатай хувьчилж төсөвтөө алдагдалтай, төвлөрсөн хөрөнгө оруулалт хийх чадвар муутай төр байвал түүнийг эдийн засгийн хувьд ямар төр гэх билээ. Хувьчлалын мөнгөөр хөрөнгө оруулалт хийхгүй, төсвийн цоорхойг нөхөөд байвал хөгжиж буй орнуудад зайлшгүй хэрэгтэй үндэсний эдийн засгийн ирээдүйтэй "ялагч" гэж нэрлэгддэг шинэ салбар, шинэ үйлдвэрлэлийг бий

болгох үүргийг монголын төр гүйцэтгэж чадахгүй. Ингэж төрийн эдийн засгийн роль, үүрэг эрс буурч эдийн засгийн хүч чадал нь хэт доройтож төрийн оролцоо, зах зээлийн хоорондын тэнцэл алдагдах аюулд хүрвэл үндэсний эдийн засгийг сэргээх, хөгжүүлэх тухай ярихын аргагүй болно. Хувийн хэвшил хөгжил авчирна гэсэн номыг өрөөсгөл шүтэж улсын сектор хөгжилд хэрэгтэйг мартаж болохгүй, хувьчлахыг мэддэгмөртөө бүтээхийг мартдаг төр байж таарахгүй.

Зах зээлийн эдийн засагт шилжиж буй буурай хөгжилтэй орнуудад төрийн эдийн засгийн роль өндөр байхыг эдийн засгийн онол, олон улсын амьдралын туршлага нотлоод байна.

Зах зээлийн өмнөх төрийн үүргүүдийг "эзэрхэг" гэсэн нэгэн том хараалд багтааж "бүтээлч" үүргүүдийг үгүйсгэдэг үзэл баримтлалыг няцаах, "төрөө дээдэлдэг" улс үндэстний түүхэн уламжлалыг ирээдүйн хөгжлийн хөдөлгүүр болгож ашиглах хэрэгтэй болоод байна.

Хөгжилтэй орнуудын эдийн засаг дахь төрийн үүргийг хөгжиж буй орнууд шууд хуулбарлаж хэрэглэвэл тэр улс орон эзэнгүйдэлд орж үндэсний эдийн засаг нь сүйрэлд өртөх аюултай.

Шилжилтийн эдийн засагтай, буурай хөгжилтэй орнуудад дараах олон үүргийг төр гүйцэтгэнэ. Үүнд:

- Зах зээлийн эдийн засгийн эрх зүйн орчин бүрдүүлэх; нэгд, шинэ хуулиуд баталж гаргах; хоёрт, хууль гартал түүний цоорхойг нөхсөн журам, заавар гаргах давхар үүрэг.
- Байгаль орчин, нөхөн сэргэгдэхгүй нөөц баялгийн эзэн байх үүргүүд.
- Хүн амын эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үүргүүд.
- Боловсрол, соёл, шинжлэх ухааныг хөгжүүлэх үүргүүд.
- Үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах үүргүүд.
- Хөдөөгийн хүн амыг хотын дамчдаас хамгаалах эдийн засгийн үүрэг.
- Үндэсний эдийн засагт "ялагч" сектор шинээр бий болгож, шаардлагатай үед хувьчлах үүрэг.
- Улсын секторыг төлөөлж зах зээлд субъектын хэлбэрээр шууд оролцох үүрэг.
- Улсын үйлдвэр, үйлчилгээний газруудын, дотооддоо болон гадагшаа өрсөлдөх нөхцөлүүдийг бий болгох, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх замаар дампуурлаас урьдчилан сэргийлэх, хамгаалах үүргүүд гэх мэт.

Эдгээр үүрэг тус бүрээр нарийвчилсан судалгаа хийгээд үр дүнг нэгтгэвэл сайн чанарын судалгаа болно.

Шилжилтийн нөхцөлд зах зээлийн эдийн засгийн байхгүй байсан эрх зүйн хангамж, нийгмийн таатай орчинг төр бий болгож байна. Зах зээлд бүрэн буюу хагас хэсгээр багтахгүй байгаль орчин, нөхөн сэргээгдэхгүй нөөц баялаг болон хүн амын эрүүл мэнд, боловсрол, соёл, шинжлэх ухаан үндэсний батлан хамгаалах гээд олон асуудлыг төр зохицуулахаас өөр аргагүй. Эдгээр үүргийг дутуу биелүүлж байгаа гэсэн үнэлгээг Монголын төр авах ёстой.

Нийгмийн секторыг төлөөлж, зах зээлд шууд субъект болон оролцох том үүргийг монголын төр биелүүлэхийг хүсэхгүй байна. Монголын төр татвар төлөгчдийн мөнгө, хувьчлалын орлого, гадаадын зээл тусламжийн хөрөнгө бүгдийг зохицуулж, заримыг эзэмшиж байгаа. Нэг үгээр, монголын төр бол монголын хамгийн том хөрөнгөтөн. Хөгжиж буй орнуудад "ялагчдыг" сонгоход төр идэвхтэй үүрэг гүйцэтгэдэг онцлог Монгол оронд ч хамаарагдана. Ялагчид гэж харьцангуй давуу талтай, бүх талын тусламж төрөөс авах хэрэгцээ бүхий ирээдүйтэй салбаруудыг хэлж байгаа юм. Хөгжиж буй орнуудын хөгжлийн эхний шатанд эдийн засаг дахь төрийн оролцоо нэлээд хүчтэй байсныг шинээр үйлдвэржсэн орнуудын

туршлага чнотлож байна. Эдгээр оронд төрийн тусламжгүйгээр хөрөнгө оруулалт ихтэй салбарууд хөгжих, шинжлэх ухаан, техникийн хөгжлийн өндөр үнэтэй хөтөлбөрүүд хэрэгжих боломжгүй, улмаар дэлхийн аж ахуй, дэлхийн зах зээлд одоогийн эзэлж буй байр сууриндаа хүрч чадахгүй байсан нь тодорхой.

3.2. Зах зээлийн эдийн засгийн шинэ суурь тавих гол үүрэгтэй хувьчлалын үйл явц Монгол оронд амжилттай явагдаж байна. Энэ нь ДНБ-ий ихэнх хэсэг хувийн секторт оногдох болсноос тодорхой. Үүний хамт өмнөх үеэсээ өвлөсөн хөрөнгийг үрэн таран хийж "хувьчлахын төлөө хувьчлал" явуулж нэр хүндийг нь гутаах, үүний эсрэг бас хэт туйлшралын улмаас нийтийн секторыг ад үзэх онол, практикийн алдаа засаг төрийн бодлогын түвшинд гарсаар. Эрх тэгш байдлыг эдийн засагт хангахын тулд хувьчлалтай хамт нийгэмчлэл бас байх ёстой. Харамсалтай нь, нийгэмчлэлийн тухай асуудал Үндсэн хуульд орхигдсон юм. Үүний хамт ад үзэгдэх болсон нийтийн секторын ашиг сонирхлыг хувийн секторын түвшинд сэргээж тавих шинэ асуудалтай тулгарч байна. Төрийн хөрөнгөөр үйлдвэрлэл, үйлчилгээг шинээр бий болгох, дараа нь хувьчлах, хувийн хэвшилтэй төр хамтарч шинээр хөрөнгө оруулах боломжууд зах зээлийн эдийн засагт нээлттэй байх учиртай. Эдгээр боломжийг Монголын төр дутуу ашиглаж байна.

Улсын сектор, улсын үйлдвэр хүүхэд айлгадаг "мангаа" биш, жишээ нь, Англид "Бритиш коул" гээд хэд хэдэн том нэгтгэл улсын секторт үлдсэн хэрнээ хувьчлагдсан хэсгээс дутахгүй амжилт олсон туршлага бий. Хувьчлал нь өөрөө бүхнийг бүтээдэг "бурхан биш", үйлдвэрүүдийн үйл ажиллагаанд үндсэн өөрчлөлтийг тэр өөрөө шууд авчрахгүй. Харин тийм эх үүсгэвэр бол өрсөлдөөн үүсгэх нөхцөлүүд байдаг. Ийм л эх үүсгэвэртэй бол улсын үйлдвэр бүр амьдарч чадна. Энэ шалгуурыг бас хувьчлалд ч хамааруулах учиртай.

3.3. Зах зээлд шилжих явцад эс үйлдвэржих (деиндустриализаци) үйл явц Монголд явагдах боллоо гэсэн гайхширалтай дүгнэлт гарсан юм. Бодит байдал дээр, статистикийн тоо баримтууд иймэрхүү зураг харуулж байна. Дотоодын нийт бүтээгдэхүүнд 10 жилийн өмнө 35 хувьтай байсан аж үйлдвэр (I) одоо 20 хувьтай, 15 хувьтай байсан хөдөө аж ахуй (A) одоо 35 хувьтай болоод байна. Ингээд, 50 хувьтай байсан үйлчилгээний салбар (S) 45 хувьтай болсныг бодолцвол, шилжилтийн 10 гаруй жилд үндэсний эдийн засгийн салбарын бүтэц SIA загвараас SAI загварт шилжсэн байна. Энэ нь олон шалтгаантай боловч, гол нь үнэ, санхүүжилтийн тогтолцоо үндсээрээ өөр болсонтой холбоотой. Үүнээс гадна, орон нутгийн болон улсын том үйлдвэрүүд уналтанд орж сэргэлт, сэлбэлт авахгүй болсныг эс үйлдвэржих процесст хамруулан ойлгох нь зөв. Энд бас шилжилтийн хүндрэлийг даах, давах илүү чадвартай салбар нь Монгол оронд хөдөө аж ахуй, түүний дотор мал аж ахуй байсныг цохон тэмдэглэвэл зохилтой.

3.4. Эс үйлдвэржих үйл явцын зэрэгцээ хотжихын оронд хөдөөжих үйл явц Монголд явагдаж байгаа нь хачирхалтай. Амьдрах арга хайсан хотынхон хөдөөд гарч, салбарын бүтээмжийг унагаж байгаа нь сайшаагаад байх хэрэг биш бололтой. Хэзээ нэгэн цагт энэ үйл явц буцаж эргэх нь лавтай.

Дүгнэлт, санал

Үндэсний эдийн засгийнхаа байдалд бодит үнэлгээ өгч сураагүй, харин гадны үнэлгээг сонсч сайныг нь аваад магтаал, ерөөл болгодог буруу зуршилтай болсон. Ийм байдал нь хүний үгээр үг хийж бодит байдлыг өөрийн нүдээр харах чадваргүй болгоно.

Барааны хомсдолоос үнэ өсч, үнэ өссөнөөс инфляц давхарч, инфляц даварснаас үндэсний валютын ханш буурч, хүн амын бодит орлого буурч ядуурал өсдөг гинжин холбоог тоон хэл дээр буулгаж харилцан хамаарлыг нь зөв тогтоож чадвал үндэсний эдийн засгийн өнөөгийн

байдалд бодит үнэлгээ өгч чадна. Харамсалтай нь, Үндэсний ийм судалгаа алга.

Одоогийн байдлын урт гинжин холбоог буцаагаад гогцоо бүрээр задлан шинжилж, тухайлбал: ажил эрхлэлтийг нэмэгдүүлж, бүтээмжийг дээшлүүлж бодит орлогыг нэмэгдүүлж хүн амын ядуурлыг арилгах, үнийг тогтворжуулж, инфляцийг дарж үндэсний валютын ханшийг өсгөж чадах арга ухааныг олоход ирээдүйгээ харсан эдийн засгийн бодлогын утга учир оршино. Эндээс л төсвийн бодлого, мөнгөний бодлого, хөрөнгө оруулалтын бодлого, валютын бодлого, худалдааны бодлого гээд олон бодлого эхээ авч энд л бас эцсийн бүлэгт бүгд зангилагдах ёстой.

Санхүү, мөнгөний бодлогоор эрэлтийг зохицуулан жолоодож, улмаар үндэсний орлогын тэнцлийг өөрчлөх чадвар төр, засагт бий. Үндэсний орлогын нэгэн үзүүлэлтээр макро эдийн засгийн дотоод, гадаад тэнцлийг хангах хоёр зорилтыг нэгэн зэрэг шийдэж чадна. Жишээ нь, үндэсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх үр дүнд хүрье гэвэл: Засгийн газрын зардлыг хасч үйлдвэрлэлд нэмэх, татварын өсөлтийг бууруулж хүн амын хэрэглээг өсгөх, мөнгөний бодлогоор хүүг бууруулж хөрөнгө оруулалт хийх хэрэгтэй. Ийм мэдлийг зах зээл Засгийн газарт олгодог.

Судалгаагүй бодлого, бодлогогүй шийдвэр гаргах нь засаглалын нэр хүндийг гутаах аюултай. Жишээ нь: импортын татварыг тэглэж байсан, эргээд сэргээж байсан. Импортын барааны үнэ хямдарч барааны хангамж нэмэгдэх сайн талтай боловч дотоодын зах зээлийг гадны бараагаар дүүргэж өрсөлдөх чадваргүй үндэсний үйлдвэрлэлийг сөнөөх аюултай. Энд үндэсний үйлдвэрлэлийг дэмжих бодлого алга болж байгаа юм.

Ингэлээ гээд, бараа бүхэнд өндөр татвар тогтоогоод эхэлбэл, Дэлхийн Худалдааны байгууллагын өмнө хүлээсэн үүргээ тасалж чөлөөт худалдааны хүрээнээс гарч эхэлнэ. Бараа нэг бүр дээр тодорхой харах хэрэгтэй. Үнийн мэдрэмжтэй бараанд зохих хэмжээний тариф, үнийн мэдрэмжгүй бараанд тарифын биш арга, экспортын ноолуур мэт онцгой бараанд квот, лиценз, татаас хэрэглэх, хөгжиж буй оронд оногдох хөнгөлөлт хүсэх гээд Засгийн газарт бас ч гэж боломж бий. Гадаадад гаргах барааны нэр төрөл цөөн, тоо хэмжээ нь бага байгаагийн дээр худалдааны нөхцөл жилээс жилд муудсаар байна. Сүүлийн жилүүдэд (1995-1999) импортод оногдох монголын экспортын худалдан авах чадвар 7.3 хувиар буурчээ гэсэн судалгаа бий. Энэ бол дэлхийн зах зээл дээрх орлогын хуваарь Монгол улсад ашиггүй явагдаж байна гэсэн үг. Гадаад худалдаа цаашид ийм байдлаар үргэлжилбэл монголын эдийн засагт өсөлт биш, уналт-авчирна гэсэн үг.

Экспортын хомсдолоос валютын дутагдал үүсч, валютын хомсдолоос технологийн хоцрогдолд орж, технологийн хоцрогдолоос үндэсний бүтээмж доройтож байна. Энэ байдлаас ангижрах эхний бөгөөд шийдвэрлэх гарц нь монголын экспортыг өсгөх явдал мөн. Үүний тулд үйлдвэрлэлийн хүчин зүйлсийн нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, тухайлбал шинэ технологийн бааз дээр үндэсний үйлдвэрлэлийн бүтцэд шинэ гүнзгий өөрчлөлт хийх шаардлагатай байна. Энэ бол экспортыг дэмжих бодлогыг гадаад худалдааны бодлогоос гадна гадаадын хөрөнгө оруулалт, ялангуяа шууд хөрөнгө оруулалт, гадаадын зээл, тусламжаар техник, технологи оруулах, шинэ үйлдвэрлэл эзэмших үйлдвэржүүлэх бодлогоор дэмжих хэрэгтэй гэсэн үг.

Монголын төр хүн төвтэй бодлого явуулж байна гэдэг. Хүн капиталд (боловсрол, эрүүл мэнд, шилжилт) оруулсан хөрөнгө түүний бүтээмжийг дээшлүүлж, улмаар цалин хөлс, орлогыг нэмэгдүүлнэ. Үүний дүнд хүн амын ядуурал багасч, үндэсний орлого ч бас нэмэгдэнэ. Гэтэл боловсрол сайтай орон гэсэн олон улсын үнэлгээнээс (96.5% байснаа 82.2%) Монгол Улс холдож явна. Амьдралын нөхцөл муудсанаас хүүхдүүд сургууль завсардаж, мэргэжлийн

нэр хүнд буурч мэргэшилтэй ажилтнууд орлого хөөцөлдөх болов. Хүн капитал бол үндэсний бүтээмжийг өсгөх анхдагч бөгөөд шийдвэрлэгч эх сурвалж болох учир хүн капиталын хөгжилд гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх бодлого явуулах ёстой.

Энэ бүхэн бол шилжилтийн эдийн засгийн шинжлэх ухааны судлах зүйлсийн зөвхөн нэг хэсэг. Түүнд өөрийн гэсэн зарчмууд, онолууд, загварууд, бодлогууд бий, судлах, суралцах зүйл маш их байна.

Эцэст нь тэмдэглэхэд, шилжилт ба хөгжил бол харилцан шүтэлцээтэй үйл явц билээ. Хөгжихийн төлөө бид шилжилтийг сонгосон, шилжилтийн үндэс нь бас хөгжил юм. Тодорхой хэлбэл: эдийн засгийн уналт шилжилтийг саатуулж, шилжилтийн удаашралт хөгжлийг чөдөрлөж байна. Энэ утгаар, шилжилтийн эдийн засгийн шинжлэх ухааныг хөгжиж буй орнуудад зориулагдсан гадаадын шууд хөрөнгө оруулалтын загвар, галуун цувааны онол, шаталсан хөгжлийн онол, тэгш биш хөгжлийн онол, дуалист онол, гүйцэх, зэрэгцэх, утгах стратеги гэх мэт олон онол загвартай эдийн засгийн шинжлэх ухааны бас нэгэн салбар хөгжлийн эдийн засгийн шинжлэх ухаанаар баяжуулах шаардлагатай. Манай орны шилжилтийн практикт энэ хоёр шинжлэх ухааныг хослуулж хэрэглэх онцлогтой.